



**МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 25 өдөр

Дугаар 1/38

Мандалговь

Г Аймгийн түүх соёлын үл хөдлөх дурсгалын
улсын тооллогыг зохион байгуулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.3, 16.1.5, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Түүх соёлын үл хөдлөх дурсгалын тооллого хийх журам” болон Соёл урлагийн газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 06-ний өдрийн A/14 дугаар тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Дундговь аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг 2022 оны 03 дугаар улиралд багтаан зохион байгуулсугай.

2. Улсын тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч Х.Цогзолмаа (Соёл урлагийн газрын дарга)

Гишүүд: М.Бямбажав (Музейн захирал)

Б.Шинэбаяр (Музейн эрдэм шинжилгээний ажилтан)

Ж.Мөнхцэцэг (Музейн буртгэл мэдээллийн санч)

Б.Баярмаа (Музейн боловсролын ажилтан,
тайлбарлагч)

Нарийн бичгийн дарга Ё.Нэргүй (Соёл урлагийн газрын соёл, гэгээрлийн
асуудал хариуцсан мэргэжилтэн)

3. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогыг холбогдох хууль, журам, удирдамжийн дагуу зохион байгуулж, тайлан мэдээг хугацаанд нь гарган танилцуулахыг ажлын хэсэг (Х.Цогзолмаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

М.АНХБАЯР



4822111145